

Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга,
нийтлэг стандартыг тогтоох тухай журмын 10 дугаар хавсралт

Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс,
төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр

Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэр Аймгийн Засаг дарга

(Хуулийн 6.4.8, 6.8.1 заалтын хүрээнд)

Д/д	Шийдвэр гаргагч	Шийдвэрийн огноо	Шийдвэрийн дугаар	Төрөл/хөрөнгө зарцуулах, өр авлага үүсгэх	Шийдвэрийн хуулбар
1	Аймгийн Засаг дарга	2022.04.04	Б/19	Дэмжлэг үзүүлэх тухай	
2	Аймгийн Засаг дарга	2022.04.19	А/118	Хөрөнгө зарцуулах тухай	

Төрийн сангийн мэргэжилтэн: Б.Гантулга



Холбогдох утас: 70384096, 88089938
И-мэйл хаяг: b.gantulga@khs.gov.mn



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 19 өдөр

Дугаар А/Н8

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн ээлжит IX хуралдааны 05 дугаар, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Нийтийн номын сангийн сан хөмрөгийн баяжилтыг нэмэгдүүлэх, орчин нөхцөлийг сайжруулах үйл ажиллагаанд 10,000,000 (Арван сая) төгрөгийг зарцуулсугай.
2. Дээрх зардлын 10,000,000 (Арван сая) төгрөгийг Засаг дарга дансны аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тусгагдсан зарим арга хэмжээг санхүүжүүлэх зардлаас гаргаж зарцуулахыг Төсвийн ерөнхийлөн захирагчийн Ерөнхий нягтлан бодогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Батжаргал)-д зөвшөөрсүгэй.
3. Зардлыг зориулалтын дагуу зарцуулахыг аймгийн Нийтийн номын сангийн захирал (Э.Даваачулуун), нягтлан бодогч (Д.Энхсайхан) нарт тус тус үүрэг болгосугай.
4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 09 өдөр

Дугаар 5/19

Мөрөн сум

Дэмжлэг үзүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 15 дугаар зүйлийн 15.1; Биеийн тамир спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 05 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 11 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сэлэнгэ аймагт зохион байгуулагдах волейболын идэрчүүдийн Улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох баг тамирчдын хоол, байрны зардалд 500,000 (Таван зуун мянга) төгрөг, Улаанбаатар хотын Багануур дүүрэгт зохион байгуулагдах шатрын спортын өсвөр үеийн Улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох баг тамирчдын замын зардалд 1,000,000 (Нэг сая) төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүлсүгэй.

2. Дээрх дэмжлэгийн 1,500,000 (Нэг сая таван зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг дарга дансны Иргэд, байгууллагаас ирсэн саналыг шийдвэрлэх зардлаас гаргаж зарцуулахыг аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн ерөнхий нягтлан бодогчийн албан үүргийг түр орлог гүйцэтгэгч (Л.Батжаргал) -д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат) -т үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН